



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/163

Булган сум

Замын цагдаагийн тасагт дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Цагдаагийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэг, Булган аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны XI/03 дугаар тогтоолоор батлагдсан “аймгийн Төрийн албаны хүний нөөцийг 2023-2028 онд хөгжүүлэх хөтөлбөр”, 2023 оны XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар захирамж, Хууль зүй, дотоод хэргийн сайдаас Булган аймгийн Засаг даргатай 2024 онд хамтран ажиллах гэрээний 3 дахь хэсгийн 3.1.9.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн албаны “Хамтран ажиллах тухай” хүсэлтийн дагуу Булган аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн 8 албан хаагчийн “Өөртөө хайртай 72 цаг” нөхөн сэргээх эмчилгээний зардалд 3,200,000 (гурван сая хоёр зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Шаардагдах хөрөнгийг аймгийн Төрийн албаны хүний нөөцийг 2023-2028 онд хөгжүүлэх хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

3.Хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан зардлын тооцоо, гүйцэтгэлийг гаргаж аймгийн Засаг даргын Тамгын газарт тайлагнахыг Цагдаагийн газар (цагдаагийн дэд хурандаа Г.Ганбаяр)-т, хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Одхүү)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ

